



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/30

Алтрага

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 59 дүгээр зүйлийн 59.1.13, 59.1.17 дахь заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7, 17.2.10 дахь заалт, 48 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын байгалийн нөөцийн хамтын менежментийн хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Ажлыг хэсгийн ахлагч: - Засаг даргын орлогч, Байгаль орчин, тогтвортой хөгжлийн бодлогын тасгийн дарга

Гишүүд: - ХАА-н мэргэжилтэн  
- Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн  
- Газрын даамал  
- 1 дүгээр багийн Засаг дарга  
- 2 дугаар багийн Засаг дарга  
- 3 дугаар багийн Засаг дарга  
- 4 дүгээр багийн Засаг дарга  
- 5 дугаар багийн Засаг дарга  
- Улаантайгын тусгай хамгаалалтын газрын захиргааны байгаль хамгаалагч

Нарийн бичгийн дарга: - ТНС төслийн зохицуулагч

2.Байгалийн нөөцийн хамтын менежментийн хөтөлбөр боловсруулан 2024 оны 2 дугаар улиралд багтаан Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Ажлын хэсгийн ахлагчид даалгасугай.

ДАРГА



Г.ОДСЭР

Document-Zahiramg

**6729010069**